



## БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/176/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баянхонгор хот 2020 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: Утас: 88011833 Цахим хаяг: tseenyma@audit.gov.mn Аудитор: Г.Ганчимэг Утас:88268424 Цахим хаяг: ganaa_7133@yahoo.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

Аудитын гэрчилгээ.....	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
2.13. Шилэн дансны мэдээлэл Баянхонгор аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар нь 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан аудитын дүгнэлт, тоног төхөөрөмж худалдаж авсан 9,9 сая төгрөгийн гүйлгээг байршуулаагүй байсан зөрчлийг аудитын хугацаанд байршуулж ажилласан.	10
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	11
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
Менежментийн захидал.....	12
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	16
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	20

Аудитын гэрчилгээ



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

64101 Номгон, Баянхонгор сум  
Утас, факс 70-44-25-84  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН ХҮНС  
ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН  
ДАРГА Ж.БАТТӨР ТАНАА 7

2020.02.04 № 1/37

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г Аудитын гэрчилгээ 7

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Тоот-А4

2519399


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

Тоот-А4

## Аудитын тайлан

### 2.1. Оршил

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Ж.Баттөрд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.01.26-аас 2020.01.28-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.01.28-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын Г.Ганчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газар-т 2020.01.20-ны өдрийн 1/17 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Хүнс Хөдөө Аж Ахуй, хөнгөн, жижиг, дунд үйлдвэр, хоршоо, худалдаа үйлчилгээний салбарыг зах зээлд өрсөлдөхүйц хөгжлийн шинэ шатанд гаргаж, уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг орон нутгийн онцлогт тохируулан хөгжүүлж эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх гэсэн эрхэм зорилго оршино.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Орон нутгийн эдийн засгийн өсөлтийг хангаж бүс нутгийн болон хөдөөгийн хөгжлийг дэмжих, хүнс хөдөө аж ахуйн салбарын тогтвортой байдлыг хангаж шинжлэх ухааны технологийн ололтыг үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтрүүлэхэд оршино

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" программ хангамж ашиглаж байна.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 32 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 30 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

#### **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1050412,6 мянган төгрөгөөс тооцон 21008,3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 21008,3 мянган төгрөгөөр тооцсон нь үр дүнгийн тайлангийн зардлыг суурь болгон сонгосонтой холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 608427,8 мянган төгрөгөөр буюу 41,6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өөрчлөлт
<b>Б</b>	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	16061,6	15779,0	-282,6
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	701603,0	292281,9	-409321,0
Үндсэн хөрөнгө	742539,1	543715,0	-198824,1
Нийт хөрөнгө	1460203,8	851776,0	-608427,8
Өр төлбөр	2853,6	1148,9	-1704,6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1457350,2	850627,0	-606723,1
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	1460203,8	851776,0	-608427,8

Авлага дансны үлдэгдэл буурсан нь байгууллагаас авах авлагыг барагдуулснаа шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2017-2019 онуудад үүссэн 12952,8 мянган төгрөгийн үрийн төмсний авлага, иргэн С.Лханаагаас 2827,0 мянган төгрөгийн ноолуурын болон мал дутагдуулсны төлбөрийн авлага байна. Үүнээс авлага барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй шалтгааны улмаас барагдах боломжгүй, эрсдэлтэй 11551,0 мянган төгрөгийн авлага байна. Энэ нь найдваргүй авлага үүсэх үр дагавартай.

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь бүтцийн өөрчлөлтөөр Мал эмнэлгийн газар-т ТӨБЗГ-ын тогтоолоор 400448,8 мянган төгрөгөөр бараа материал шилжүүлснээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд 2009-2019 онд худалдаж авсан 292281,9 мянган төгрөгийн бараа материал байна.

Бараа материалын дансанд 2019 оны дээд шатны төсөв захирагчаас үнэ төлбөргүй 7621,1 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлснийг байгууллагын бараа материалын дансанд бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл буурсан нь бүтцийн өөрчлөлтөөр "Мал эмнэлгийн газар-т ТӨБЗГ-ын тогтоолын дагуу 283743,5 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлснээс шалтгаалжээ. Төсвийн хөрөнгөөр 9956,1 мянган төгрөгөөр худалдаж авсан хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 283743,5 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгө өссөн шалтгаан нь системийн хэмжээнд санхүүгийн өөр программд шилжихээр 1500,0 мянган төгрөгөөр Гок софт ХХК-аас “Динамик санхүүгийн программ” худалдаж авсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь 2018 онд үүссэн өрийг бүрэн барагдуулснаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1148,9 мянган төгрөгийн өр төлбөр 2019 онд үүссэн шинээр үүссэн байна. 987,5 мянган төгрөгийн үүссэн шалтгаан нь Мал эмнэлгийн газартай халаалтын зардлыг 70/30 харьцаагаар төлж байгаагаас, 91,1 мянган төгрөгийн өр ХХОАТ-ын өглөгийг дутуу буруу тооцож, 70,0 мянган төгрөгийн өр нь албан хаагчдаас хадгаламжийн хуримтлал суутгаж аваад шилжүүлээгүй улмаас шалтгаалж өглөг үүссэн байна.

Энэ нь дансны өглөг хуримтлагдах, төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдах үр дагавартай.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 850627,0 мянган төгрөг болж 606723,1 мянган төгрөгөөр буурсан бүтцийн өөрчлөлтөөр хөрөнгө балансаас баланст шилжүүлснээс шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 84968,4 мянган төгрөгийн бичилт нь дахин үнэлгээний нэмэгдэлтэй хөрөнгө балансаас баланст шилжүүлсэн улмаас үүссэн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралттай холбоотой байна.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Баянхонгор аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар нь тайлант онд 1500,0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 2032,2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 135,4 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Малын ашиг шимийн орлого	1500,0	1500,0	0	100
Хүнсний ногоо борлуулсны орлого		500,0	500,0	
Шинжилгээний орлого		32,2	32,2	
Нийт дүн	1500,0	2032,2	532,2	100,0

Тайлант онд 532,2 мянган төгрөгийн орлого давсан нэмэлт аж ахуй эрхлэн явуулснаас шалтгаалсан

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт зориулан 324271,7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 324271,7 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 325771,7 мянган төгрөгийг улсын төсвөөс 324271,7 мянга, 1500,0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 325116,5 мянган төгрөг буюу 99,7 хувьтай байгаа нь өөрийн орлогын төлөвлөгөө 532,2 мянган төгрөг, хог хаягдалын зардал 60,0 мянга, даатгалын зардал 63,0 буюу нийт 123,0 мянган төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

**Нэмэлт төсөв:** Дээд шатны төсөв захирагчаас 109621,8 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1200,0 мянга, нийт 110821,8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс үлийн цагаан оготно устгалын зардалд 84578,7 мянга, малын генетикийн нөөцийн төлөв байдлыг үнэлэх арга хэмжээнд 22944,5 мянга, худгийн засварын ажил болон хяналтын зардалд 3298,4 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

## 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 30 эрсдэл тодорхойлж нийт 30 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 237209,9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1467,2 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 29844,0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 205898,7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал  
(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	205898,7	
2	Төлбөрийн акт тогтоосон	2	1467,2	
3	Албан шаардлага өгсөн	2	29844,0	
	Дүн	7	237209,9	

Аудитаар дараах 237209,9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 31311,2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд олгосон цалингийн зардлын гүйлгээг цалингийн цэсээс давтан тооцоолж баталгаажуулахад 4 дүгээр сард 566.7 мянган төгрөгийг цалинг албан хаагчид илүү олгож, суутгаж авсан боловч суутгасан цалинг хамтын санд төвлөрүүлсэн, мөн НДШ-ыг 210,0 мянган төгрөгөөр илүү мэдээлж байгууллагаас 50,4 мянган төгрөгийг төлсөн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх заалттай нийцэхгүй, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

2. Бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйл худалдан авах зардлаас 170,1 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнд зарцуулсан, нормын хувцасны зардлаас албан хаагчид 680,0 мянган төгрөгөөр биеийн тамирын өмсгөл хийлгэж төсвийг зориулалт бусаар зарцуулсан

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.**

3. 2017 онд 5 сумын иргэн, ААНБ-д 8724,0 мянган төгрөгийн үрийн төмс олгосон, гэрээт малчнаар ажиллаж байсан иргэнд төлбөр ногдуулж тайланд 2827,0 мянган төгрөгийн авлага тусгаж, тухай иргэнийг 2018 онд шүүхэд шилжүүлсэн боловч хариуцагчийн хаяг тодорхой бус гэсэн шалтгаанаар одоог хүртэл шийдвэрлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8. “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй Оршин байх, Эрх ба үүргийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.**

4. Баянхонгор аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын даргын 2019 оны 4 дүгээр сарын 18 ний өдрийн тушаалаар 12 суманд 303 толгой 20916,5 мянган төгрөгийн бог мал хээлтүүлэгчийг шилжүүлсэн бөгөөд 18293,0 мянган төгрөгийн хээлтүүлэгчийг орлого аваагүй, бүртгэлд тусгаагүй, Өлзийт сум хээлтүүлэгчийг орлого авсан боловч тоо толгой болон үнийн дүнг тайланд буруу тусгасан байна

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалттай нийцэхгүй Оршин байх, Эрх ба үүргийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.**

Аудитаар илэрсэн 205898,7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

**2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Шатахууны зардлыг нэр төрлөөр нь орлого авч зарлага гаргаж байгаа алдааг давтан гүйцэтгэсэн мөн аймгийн Засаг даргын 2013 оны 327 дугаар захирамжаар баталсан “Тээврийн хэрэгслийн ашиглалтын журам”-ыг мөрдсөн эсэх, авлага өглөгийг бүрэн барагдуулж тайлант зөв тусгасан эсэх авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.13. Шилэн дансны мэдээлэл Баянхонгор аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар нь 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан аудитын дүгнэлт, тоног төхөөрөмж худалдаж авсан 9,9 сая төгрөгийн гүйлгээг байршуулаагүй байсан зөрчлийг аудитын хугацаанд байршуулж ажилласан.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуулаагүй
1	Бүтэн жил	11	11	8	1	2
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	3	1	
4	Сар бүр	3	36	34	2	
5	Тухай бүр	8	96	89	6	1
6	Нийт	27	151	138	10	3

#### **2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар: Зөвлөмж өгөөгүй байна.

#### **2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баянхонгор аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

## Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 1. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

#### 1.1. Илрүүлэлт:

Шатахуун, норматив зардлыг анхан шатны баримт мөнгөн гүйлгээний журнал, бараа материалын орлого зарлагын журнал, төсвийн гүйцэтгэлтэй тулган шалгахад шатахууны зардалд 4808,0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас шатахуунд зардалд зарцуулж шатахууныг хөтөлбөрийн дагуу тушаал гаргаж зарцуулаагүй нягтлан бодох бүртгэлд нэр төрлөөр бүртгээгүй, шилжүүлсэн мөнгөн дүнгээр орлого авч, зарлага гарган тайланд тусгасан байна.

#### 1.2. Эрсдэл:

Тээвэр шатахуун, нормативт зардлыг батлагдсан төсвөөс үндэслэлгүй хэтрүүлэн зарцуулах

#### 1.3. Өгсөн зөвлөмж:

Шатахууны нэр төрлөөр орлого авч гүйцэтгэлээр зарлага гаргаж хөтөлбөр тус бүрээр байгууллагын даргын тушаалаар зарцуулах.

#### 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

### 2. Балансын данстай холбоотой:

ХХААЯ-ны хөрөнгө оруулалтаар 2018 онд ирсэн 46310.5 мянга төгрөгийн үнэтэй трактор 1 / улсын бүртгэлийн дугаар гэрчилгээ байхгүй/, 128875.0 мянган төгрөгийн 11 нэр төрлийн хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж, хүлэмжийг Тусгай зориулалтын материалын дансанд бүртгэсэн бөгөөд дуслын усалгааны системийн тоо ширхгээр орлого аваагүй нийт дүнгээр орлого авсан байна. Мөн Зөврийн ноос пресслэгч машиныг 2018 онд Шинэжинст сумын иргэнд О.Бямбатогоо-д өгсөн байхад тооллогын комисс бэлэн байгаа хөрөнгөөр тоолж тооллогын бүртгэлд тусгасан, ашиглалтын зардлыг гэрээ хийж аваагүй. 2013 онд /тухайн үеийн/ ҮХААЯ-ны хөрөнгө оруулалтаар ирсэн 5494.5 мянга 6 ш, 6711.1 мянга 3 ш ноос пресслэгч, 1045.0 мянга 6 ш, 1533.3 мянган төгрөгийн үнэ бүхий 3 ш электрон жин, Олсон таар 2547м<sup>2</sup>, төмөр утас 1350 кг-ыг тухайн үед хөдөө аж ахуйн 2 хоршоо, 7 сумад шилжүүлсэн байхад хөрөнгийн бүртгэлийг давхардуулж 1 ш 70853.6 мянган төгрөгийн



байгуулсан тооллогын комисс, мөн байгууллагын хөрөнгийн бүртгэл болон ашиглалтыг хариуцан ажиллаж байсан албан тушаалтнуудад хариуцлага тооцох.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

**3.1. Илрүүлэлт:**

Тус байгууллагын хөрөнгийн дансанд бүртгэлтэй программуудаас 650.0 мянган төгрөгийн үнэ бүхий 2003 оны программ нь ашиглалтгүй ямар программ байдаг эсэх нь тодорхой биш. мөн 2019 онд шинээр санхүүгийн "Динамик" программд шилжсэн бөгөөд хуучин ашиглаж байсан санхүүгийн тооцоох ХХК-ийн "Payroll", "Acolous" программууд элэгдлийн хугацаа дууссан бөгөөд цаашид байгууллагын үйл ажиллагаанд ашиглахгүй болсон.

**3.2. Эрсдэл:**

Ашиглалтгүй биет бус хөрөнгийг нягтлан бүртгэл, тайлангаас хасаагүй байх

**3.3. Өгсөн зөвлөмж:**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу ашиглалтгүй байгаа программ хангаж судалж холбогдох журмын дагуу шийдвэрлэх

**3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>717,664,682.20</b>	<b>308,060,999.89</b>
33	<b>АВЛАГА</b>	16,061,662.00	15,779,000.00
335	<b>Бусад авлага</b>	16,061,662.00	15,779,000.00
3351	Байгууллагаас авах авлага	13,234,662.00	12,952,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,827,000.00	2,827,000.00
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	701,603,020.20	292,281,999.89
351	<b>Түүхий эд материал</b>	606,626,482.90	219,799,600.28
35110	Тусгай зориулалттай материал	606,365,782.90	219,538,900.28
35130	Эм боох материал	260,700.00	260,700.00
354	<b>Хангамжийн материал</b>	61,024,037.30	61,356,399.61
35410	Бичиг хэргийн материал	2,768,850.00	5,385,006.31
35420	Аж ахуйн материал	38,368,066.00	38,062,472.00
35430	Сэлбэг хэрэгсэл	6,038,100.00	4,043,700.00
35440	Түлш, шатах тослох материал	10.30	16,210.30
35450	Барилгын засварын материал	304,425.00	304,425.00
35470	Бусад хангамжийн материал	13,544,586.00	13,544,586.00
35600	Мал амьтад	33,952,500.00	11,126,000.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>742,539,167.70</b>	<b>543,715,021.82</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	742,539,167.70	543,715,021.82

Баянхонгор аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2019 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	566,414,167.70	367,140,021.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	405,424,340.00	340,732,740.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-4,988,806.60	-17,641,305.28
39203	Авто-тээврийн хэрэгсэл	303,588,829.67	127,240,200.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-183,887,952.04	-111,582,576.22
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	67,523,628.74	45,980,243.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	-41,985,501.72	-29,593,751.23
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,699,870.85	22,496,070.85
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,550,241.12	-11,551,599.19
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,040,000.00	3,040,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,450,000.08	-1,980,000.12
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	176,125,000.00	176,575,000.00
39301	Програм хангамж	5,180,000.00	6,680,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-980,000.00	-2,030,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	171,925,000.00	171,925,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,460,203,849.90</b>	<b>851,776,021.71</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,853,630.76</b>	<b>1,148,989.33</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	2,853,630.76	1,148,989.33
<b>413</b>	<b>Өглөг</b>	2,853,630.76	1,148,989.33
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	787,968.76	90,661.90
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	2,065,662.00	1,058,327.43
41361	Байгууллагад төлөх өглөг	1,975,000.00	1,058,327.43
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	90,662.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,457,350,219.14</b>	<b>850,627,032.38</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,457,350,219.14	850,627,032.38
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	448,909,074.85	448,909,074.85
51101	Өмч: - төрийн	448,909,074.85	448,909,074.85
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	838,985,896.32	317,231,159.63
51210	Өмнөх үеийн үр дүн	838,985,896.32	923,954,346.39
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-606,723,186.76
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	169,455,247.97	84,486,797.90
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,460,203,849.90</b>	<b>851,776,021.71</b>

**4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,955,153,844.97</b>	<b>444,746,891.77</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>858,171,723.70</b>	<b>9,653,363.77</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	858,171,723.70	9,653,363.77
